



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/183

Улаанбаатар хот

Албаны нууцад хамаарах
мэдээллийн жагсаалт батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1.Хууль зүй, дотоод хэргийн яамны албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг нэгдүгээр, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг хоёрдугаар, Хил хамгаалах байгууллагын албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг гуравдугаар, Хил хамгаалах байгууллагын дэргэдэх Зорчигчийн мэдээллийн төвийн албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг дөрөвдүгээр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг тавдугаар, Шүүх шинжилгээний байгууллагын албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг зургадугаар, Улсын бүртгэлийн байгууллагын албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг долдугаар, Гадаадын иргэн, харьяатын газрын албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг наймдугаар, Архивын ерөнхий газрын албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг есдүгээр, Дотоод хэргийн их сургуулийн албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг аравдугаар, Хууль зүйн туслалцааны төвийн албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг арван нэгдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ тушаал гарсантай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны "Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалт батлах тухай" А/346 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Н.Мягмар/, Цагдаагийн ерөнхий газрын дарга /Т.Сүхболд/, Хил хамгаалах ерөнхий газрын дарга /Ж.Бямбасүрэн/, Хил хамгаалах байгууллагын дэргэдэх Зорчигчийн мэдээллийн төвийн дарга /А.Энхтөр/, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга /Б.Нандинболор/, Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга /Ж.Буянбат/, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /У.Болдхүү/, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга /Н.Ууганбаяр/, Архивын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Цэндсүрэн/, Дотоод хэргийн их сургуулийн захирал /О.Зоригт/, Хууль зүйн туслалцааны төвийн дарга /Л.Уянга/, нарт үүрэг болгосугай.



О.АЛТАНГЭРЭЛ

151600572
Doc.Said Tushaal.2025

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны
25 дугаар сарын 19-ний өдрийн 4/83 дугаар
тушаалын долдугаар хавсралт



УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН АЛБАНЫ
НУУЦАД ХАМААРАХ МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Д/д	Албаны нууцад хамаарах мэдээлэл
1.	Улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан, систем, сүлжээний аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн баримт бичиг, санд нэвтрэх нууц үг
2.	Улсын бүртгэлийн цахим мэдээллийн сангийн хаалттай мэдээллийг ашиглахтай холбоотой байгуулсан гэрээ, хэлцэл
3.	Улсын бүртгэлийн цахим мэдээллийн сантай холбоотой гүйцэтгэгч сонгон шалгаруулсан тендерийн баримт бичгүүд
4.	Улсын бүртгэлийн цахим мэдээллийн сантай холбоотой хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдийн холбогдох баримт материал
5.	Улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн архив
6.	Иргэний биеийн давхцахгүй өгөгдөл /гар хурууны хээ/
7.	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журмын дагуу хургуулсан танилцуулах тойм мэдээ
8.	Үндэсний гадаад паспорт, иргэний үнэмлэх, улсын бүртгэлийн гэрчилгээний загвар, тодорхойлолт, нууцлалыг баталсан тушаал, шийдвэр
9.	Үндэсний гадаад паспортын бэлдэц нийлүүлэх, бичилт хийлгэхтэй холбоотой гэрээ, хэлцэл
10.	Иргэний үнэмлэхийн бэлдэц нийлүүлэлт, хэвлэх тоног төхөөрөмжийн гэрээ, хэлцэл
11.	Иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспорт хэвлэх үйлдвэрийн холбогдох баримт бичиг, схем, хэвлэх тоног төхөөрөмж
12.	Албаны нууцад хамаарах асуудлаар эрх бүхий албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр
13.	Сонгогчдын нэрийн жагсаалт
14.	Онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн болон албаны нууцыг хамгаалах төлөвлөгөө
15.	Албаны нууцад хамаарах асуудлыг хэлэлцсэн хурлын тэмдэглэл, шийдвэр, нууц тээгч
16.	Албаны нууцад хамаарах асуудлаар төрийн байгууллага, бусад хуулийн этгээдтэй харилцсан албан бичиг
17.	Төрийн болон албаны нууцад хамаарах баримт бичиг, нууц тээгчийг хүлээлцсэн, шилжүүлсэн нотломж
18.	Төрийн болон албаны нууц баримт бичгийн бүртгэлийн дэвтэр, ажлын тайлан

---oOo---

